

## ТАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

### 5.1 Ногоон хөгжил

Зорилго: 5.1 Хүрээлэн байгаа орчны бохирдол, доройтлыг бууруулах, хамгаалах, нөхөн сэргээх, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох арга хэмжээг хэрэгжүүлнэ.

**Зорилт: 5.1.1 Төв суурин газрын орчны бохирдлын хэмжээг 4 хувиар бууруулна.**

Арга хэмжээ:

5.1.1.1 Агаарт агуулагдаж байгаа тоос тоосонцорыг хэмжих зөөврийн багажтай болж, 3 төрлийн бодисыг бүрэн хэмждэг болж, агаарын чанарын индексээр үнэлнэ.

5.1.1.2 Утаа бага ялгаруулдаг төвлөрсөн халаалтын зуухны тоог нэмэгдүүлэх

5.1.1.3 Гэр хороолол болон аялал жуулчлал, уул уурхайн бүсэд “Эко жорлон” арга хэмжээг хэрэгжүүлэх

**Зорилт: 5.1.2 "Хог хаягдлын дахин боловсруулах үйлдвэрт 2024 он гэхэд 46 тонн дахивар хогийг нийлүүлнэ."**

Арга хэмжээ:

5.1.2.1 Төв суурин газрын төвлөрсөн хогийн цэгийн талбайг шууж, булшлах

5.1.2.2 Аймгийн төвд ангилан ялгах хогийн савны тоог нэмэгдүүлэх

**Зорилт: 5.1.3 Усны бохирдол, хомсдлоос сэргийлж, шаардлага хангасан ундны эх үүсвэрээр хангагдсан хүн амын эзлэх хувь 2020 онд 26.5 байсныг 2024 онд 30 хувьд хүргэнэ.**

Арга хэмжээ:

5.1.3.1 Төв суурин газрын ундны усны чанар стандартыг сайжруулан цэвэршүүлэх төхөөрөмжийг ус хангамжийн 8 эх үүсвэрт суурилуулах

5.1.3.2 Усны сан бүхий газарт хамгаалалтын бүс тогтоох, орон нутгийн тусгай хамгаалалтад авч тэмдэгжүүлэх ажлыг зохион байгуулах

5.1.3.3 Булаг шанд, усыг түшиглэн хур тунадас, цас, мөсний усыг хуримтлуулах хөв цөөрөм байгуулах

5.1.3.4 Булгийн эхийг хашиж хамгаалах, тохижуулах ажлыг зохион байгуулах

**Зорилт: 5.1.5 Ногоон байгууламжийн хэмжээ 2020 онд 369.4 га байсныг 2024 онд 413.4 га-д хүргэнэ.**

Арга хэмжээ:

5.1.5.1 Төв зам дагуу ногоон байгууламжийг бий болгох

5.1.5.2 Аймгийн хэмжээнд 4 га талбайд ойн зурвас байгуулах

**Зорилт: 5.1.6 Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн нийт газарт ногдох нөхөн сэргээсэн талбайн эзлэх хувь 2020 онд 8.3 байсныг 2024 онд 24.6 хувьд хүргэнэ.**

Арга хэмжээ:

5.1.6.1 Уул уурхайн болон бусад үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газарт техникийн нөхөн сэргээлтийг 100 га-д хийлгэх

5.1.6.2 Уул уурхайн болон бусад үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газарт биологийн нөхөн сэргээлтийг 25 га-д хийлгэх.

5.1.6.3 Уул уурхайн үйл ажиллагааны байгаль орчинд учирсан хохирлын үнэлгээ тооцуулах.

**Зорилт: 5.1.7 Тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ 2020 онд 27 хувь байсныг 2024 онд 33.8 хувьд хүргэнэ.**

Арга хэмжээ:

5.1.7.1 Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нэмэгдүүлэх шийдвэр гаргуулах

5.1.7.2 Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нэмэгдүүлэх шийдвэр гаргуулах